

## ХЯТАДЫН 1925—1927 ОНЫ ХУВЬСГАЛ

Ж. БЯМБАСҮРЭН

Хятадын ард түмний хувьсгалт тэмцлийн түүхэнд томоохон үйл явдлын нэг болсон 1925—1927 оны хувьсгал нь гол шинж чанарын хувьд империализмыг эсэргүүцсэн үндэсний чөлөөлөх тэмцэл байлаа. Хувьсгалд улс төрийн ухамсар, зохион байгуулалтаараа харилцан адилгүй олон янзын хүчнүүд өөр өөр зорилго өвөрлөн оролцжээ. Тэгэхдээ гадаадын эзлэн түрэмгийлэгчид болон дотоодын милитаристуудын ноёрхлыг устгахад чиглэсэн гол зорилт хүн амын олон анги давхаргын төлөөлөгчдийг хувьсгалт тэмцэлд нэгтгэж байв.

Аугаа их Октябрийн социалист хувьсгалын чөлөөлөгч үзэл санаа хятадын ард түмний хувьсгалт хөдөлгөөний хөгжилтөд гүн гүнзгий нөлөөлсөн билээ. Түүний хувьсгалжуулагч үзэл санааг Хятадын ардчилсан үзэлтэн Сун Ятсен, коммунист намыг үндэслэн байгуулагчийн нэг Ли Дажао зэрэг тэргүүний хүмүүс өргөнөөр сурталчилж байсан юм. Сунь Ятсен 1918 оны хавар В. И. Ленинд явуулсан баярын цахилгаандаа: «Хятадын хувьсгалт нам танай хувьсгалт намын удирдан явуулсан хүнд хэцүү тэмцлээр гүнээ бахархаж, Хятад, Оросын хувьсгалт намууд нь хамтын тэмцэлд нэгдэн нягтарна гэдэгт найдаж буйгаа илэрхийлье»<sup>1</sup> гэжээ.

Хятадад империализмын түрэмгийллийг эсэргүүцэн өрнөсөн 1919 оны «5 дугаар сарын 4-ний хөдөлгөөн» (Усы юньдун) нь тус орны дотор ажилчин ангиар удирдуулсан шинэ ардчилсан болон үндэсний эрх чөлөөний хувьсгалт хөдөлгөөн хүчтэй өрнөх, марксизм-ленинизмын үзэл санаа түгэн дэлгэрэх, дэвшилт сэхээтнүүд хувьсгалт тэмцэлд идэвхтэй оролцоход их ач холбогдолтой үйл явдал болов.

1921 онд Хятадын Коммунист нам байгуулагдсаны үрээр Хятад оронд ажилчны хөдөлгөөн, улс төрийн тэмцэл ихээхэн өргөн далайцтай өрнөж эхэлжээ.

1920-иод онд Америк, Япон, Англи зэрэг империалист улсууд Хятад оронд дахин түрэмгийлж, тэдний гар хөл болсон Хятадын цэргийн харгис эрхтний бүлэглэлүүд өвөр хороондоо өрсөлдөн дайтаж байсан нь тус орныг бутралын байдалд оруулж, үндэсний нэгдлийг сулруулж байв. Ийм нөхцөлд ХКН-тай хамтран ажиллах, ЗХУ-тай холбоо тогтоох, ажилчин, тариачныг дэмжих тухай Сунь Ятсений улс төрийн гурван чиг зорилтыг хэрэгжүүлэх, Гоминьдан намыг шинэчлэн байгуулахад ХКН идэвхтэй оролцлоо.

1924 оны нэгдүгээр сард Гуанжоуд хуралдсан Гоминьдан намын 1 их хурал ХКН ба Гоминьдан намын улс төрийн эвслийн үндсэн дээр империализмыг эсэргүүцэх үндэсний нэгдсэн фронтыг албан ёсоор бүрэлдүүлж, дээрх улс төрийн гурван чиг зорилтыг тусгасан тунхаг батлав: Энэ хуралд Ли Дажао, Цюй Цюбо зэрэг коммунистууд ХКН-ыг төлөөлөн оролцсон нь чухал ач холбогдолтой болсон юм.

Коммунистуудыг бүрэлдэхүүндээ багтаан Гоминьдан нам шинэчлэн байгуулагдсанаараа үндэсний нэгдсэн фронтын зохион байгуулах цөм

1. Пын Мин. История китайско-советской дружбы. М, 1959. 68-р тал.

болон хувирав.<sup>2</sup> Гоминьдан намыг ингэж улс төр, зохион байгуулалтын талаар шинэчлэн байгуулахад коммунистууд асар их үүрэг гүйцэтгэсэн билээ.

Хятадад империализм, феодализмыг эсэргүүцсэн ажилчин тариачны хөдөлгөөн өрнөж, үндэсний нэгдсэн фронт байгуулагдсан нь 1925—1927 оны хувьсгалыг урьдчилсан нөхцлийг бүрдүүлж, хувьсгалыг түргэтгэжээ. 1925 онд Шанхай хотноо өрнөсөн «5 дугаар сарын 30-ны хөдөлгөөн» Хятадын 1925—1927 оны үндэсний хувьсгалын эхлэл болов. Тавдугаар сарын 30-нд Шанхайн 2000 гаруй оюутан империалистуудын түрэмгийллийг эсэргүүцэн жагссанд Английн суурин газар (сеттльмент)-ын цагдаа нар жагсагчдаас хэдэн зуун хүнийг баривчлав. Тэгэхэд нь 10 мянга гаруй оюутан, ажилчид цагдаагийн газрын дэргэд цугларч баривчлагдсан хүмүүсийг суллахыг шаарджээ. Цагдаа нар хариуд нь гал нээж 10 хүнийг алж, 15 хүнийг хүнд шархдуулан, 53 хүнийг баривчилсан байна.<sup>3</sup> Энэ хэрэг явдал Хятадын ард түмний дургүйцлийг төрүүлж, хувьсгалт тэмцлийн галыг улам бадраав. Зургадугаар сарын 1-2-нд Шанхай хотод 200 мянга гаруй ажилчид ажил хаяж, худалдаачдын олонх нь пүүс дэлгүүрээ хаан, 50 мянга гаруй оюутан, сурагчид хичээл хаяж, империализмыг эсэргүүцсэн бүх нийтийн ажил хаялт, сүрт жагсаал явуулжээ. 6 дугаар сарын 7-нд ХКН-ын санаачилгаар империализмыг эсэргүүцэх нэгдсэн фронтын удирдах байгууллагын үүргийг гүйцэтгэх Шанхайн ажилчин, худалдаачин, оюутны нэгдсэн хороог байгуулав. Энэ нэгдсэн хороонд «бусдыгаа удирдах хамгийн нөлөөтэй байгууллага» бол үйлдвэрчний эвлэлийн ерөнхий зөвлөл байлаа.<sup>4</sup>

Шанхайн ажил хаягчдыг дэмжиж Бээжин, Ханькоу, Наньжин, Тяньжин, Циндао, Чуулалт хаалга зэрэг бусад олон хотод ажил, хичээл хаях, улс төрийн жагсаал, цуглаан хийх хөдөлгөөн удаа дараа гарав. Энэ тэмцэл хөдөлгөөн Сянган (Гонконг), Гуанжоу (Кантон)-д мөн хүчтэй өрнөж, 1925 оны 6-р сарын 19-нөөс эхлэн 16 сар үргэлжилсэн «Сянган-Гуанжоугийн их ажил хаялт» явагдсан юм. Түүний явцад Гуандунгийн хувьсгалын бааз газрууд бэхжив.

Шанхай, Сянган, Гуанжоу болон бусад хотуудад гарсан хувьсгалт хөдөлгөөний манлайлагч гол хүчин нь ажилчин анги байсан бөгөөд оюутнууд түүнд идэвхтэй үүрэг гүйцэтгэж байв.

Хятадын ажилчин ангийн энэ тэмцэл дэлхийн олон орны хөдөлмөрчид, ялангуяа ЗХУ-ын зүгээс бүх талын дэмжлэг тусламж хүлээж байв. Тэр үед МАХН, Ардын засгийн газар мөн Хятадын хөдөлмөрчдийн тэмцэлд зүйл бүрийн дэмжлэг үзүүлсэн юм.

1925—1927 оны хувьсгалын үед тэмцлийн олон арга хэлбэр хэрэглэж байсны дотор Зэвсэгт тэмцэл чухал үүрэгтэй байв. 1925 оны долдугаар сарын 1-нд Гуанжоугийн хувьсгалт засгийн газрыг Үндэсний засгийн газар, хувьсгалд оролцсон цэргийн ангиудыг Үндэсний хувьсгалт арми болгон өөрчлөн зохион байгуулжээ.

Хятадын үндэсний хувьсгалт арми үүсч бэхжихэд улаан армийн нэрт жанжин В. К. Блюхер зэрэг зөвлөлтийн цэргийн зөвлөхүүд их хувь нэмэр оруулсан юм.

Ажилчин, тариачны хөдөлгөөн улам идэвхжиж, коммунист намын нэр хүнд, нөлөө өсөн нэмэгдэж байсан тэр үед Хятадын үндэсний хөрөнгөтнүүд хувьсгалын удирдах эрхийг булаан авлаа. 1926 оны гуравдугаар

2. Новейшая история Китая. 1917—1927. М. 1983. 153-р тал.

3. Зян Бозан, Шу Шунжэн, Ху Хуа. Дундад улсын түүхийн тойм. Өвөр Монголын боловсролын хэвлэлийн хороо, 1986. 230-р тал.

4. Л. Геллер. Национальное движение и рабочий класс. «Рабочий Китай» м, 1926, 81р тал.

сарын 20-нд Чан Кайши цэргээ илгээж, Хуанпу (Вампу)-ийн цэргийн сургууль болон Үндэсний хувьсгалт арми дахь зарим коммунистуудыг баривчилж, ЗХУ-ын цэргийн зөвлөхүүдийн орон байрыг бүслэн тэднийг хувьсгалт армиас гарахыг шаарджээ. Ингэж үндэсний хувьсгалт армийн удирдлага хэрэг дээрээ Чан Кайшийн гарт оржээ. Гэвч Хятадад нэгэнт өрнөсөн хувьсгалт хөдөлгөөнийг Чан Кайшийн бүлэг бүрмөсөн устгаж чадаагүй юм.

1926 оны 7-р сараас Үндэсний хувьсгалт арми Японыг түшсэн Жан Золин болон Англи—Америкийн гар хөл болсон У Пэйфу, Сунь Чуаньфаны бүлгийн эсрэг хийх умардын дайныг эхлэж, 10-р сар гэхэд Хунань, Хубэй мужид У Пэйфугийн цэргийг бут цохисноор үндэсний засгийн газар Гуанжоугаас Уханьд шилжих бололцоотой болжээ. 1926 оны 10-р сараас 1927 оны 3-р сар хүртэлх хугацаанд үндэсний хувьсгалт арми милитарист Сунь Чуаньфаныг хөөн зайлуулж Наньчан, Нанкин, Шанхай зэрэг чухал төвүүдийг эзлэн авчээ. Умардын энэ дайнд Хятадын коммунистууд, түүнчлэн Зөвлөлтийн цэргийн зөвлөхүүд идэвхтэй үүрэг гүйцэтгэсэн билээ. Тухайлбал, цэргийн ерөнхий зөвлөх В. К. Блюхер уг дайны төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд гоминьданы хувьсгалт засгийн газрын улс төрийн зөвлөх нь М. М. Бородин байлаа.

Тэр үед хувьсгалт тэмцлийн гол төв нь үйлдвэрийн ажилчид ихтэй Шанхай хот болов. Хятад дахь хувьсгалт тэмцлийн өрнөлт империалист улсуудын эрх ашгийг ноцтой хөндсөн учраас Дорнод Хятад, Яньзы мөрний эрэгт тэд цэргийн их хүч хуралдуулан 1927 оны 3-р сарын 24-нд Нанкиныг цэргийн хүчээр дайрчээ. 1927 оны 4-р сарын 18-нд Нанкинд Чан Кайши гоминьданы засгийн газрыг байгуулж, түүнд Уханьд шилжин очсон Гуандунгийн үндэсний засгийн газар нэгдсэнээр Гоминьданы намынхан нэгдсэн фронтоос бүрмөсөн тасран салав. Ийнхүү үндэсний хөрөнгөтнүүд харгис хүчинтэй эвсэн сүлбэлдэж, хувьсгалын үйл хэргээс урван тэрсэлсэн нь Хятадад өрнөсөн 1925—1927 оны үндэсний хувьсгалын дарагдахад хүрсэн гол шалтгаан бөгөөд түүний сургамж нь Хятадын ард түмний хувьсгалт үзэл санааны цаашдын өрнөлт хөгжилтөд онцгой нөлөө үзүүлсэн билээ.